



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 473

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 383,803,000.00 (гурван зуун наян гурван сая найман зуун гурван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Хан-Уул, Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА


1225010097

۳ .. مصنفی در نشر و توزیع و حقوق نشر و کپی رایت و حقوق معنوی در نشر و کپی رایت
نویسنده (۱) - مصنف (۲) - مستشار و مستشاران ..



مستشار در امور حقوقی
مستشار در امور حقوقی

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 04 дугаар сарын 06 -ны
өдрийн 03 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Шилжүүлэн авах байгууллага
1	Телехяналтын камер	2024	Багц	10	39,817,000.00	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
2	Телехяналтын камер	2024	Багц	17	61,566,000.00	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
3	Телехяналтын камер	2024	Багц	31	116,510,000.00	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
4	Телехяналтын камер	2024	Багц	6	23,748,000.00	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
5	Телехяналтын камер	2024	Багц	8	27,688,000.00	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Телехяналтын камер	2024	Багц	31	114,474,000.00	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн				103	383,803,000.00	